ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Дилав хутагт Жамсранжавын гудамж, 31 дүгээр хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16094
Утас: 7711 8999, Цахим шуудан: ncto@gemtel.moh.gov.mn

2024.09.10 № 02/1229

танай ____________-ны №____________-т

САММИТМЕДИКАЛ СЕРВИС ХХК - Д

Тус төвөөс зарласан ЭМЯ/20240102091 тоот “Гэмтэл согог судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” тендер шалгаруулалтад ирүүлсэн тодруулгад хариу хүргүүлж байна. Үүнд:

Хавсралт 9 хуудас.

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ ДАРГА Ц.ЭНХБАЯР

ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ • ТЕНДЕРИЙН ХОРОО • ТТМ0439 •. 9077219 • УЛААНБААТАР ХОТ

1624090950

e:/my document/2024/-A

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирлын 2024 оны 9 сарын 10-ны 04/1629 тоот бичгийн хавсралт

| № | Тодруулгын асуулт | Хариулт |
|---|---|---|
| A) | Соронзон резонанст томографийн аппаратын техникийн үзүүлэлтийн *“9. Coil (Стандарт): - Wrist 18 ch – аас багагүй”* гэж шаардсан байна: | |
| | - <u>Өөрчлүүлэх хүсэлт 1:</u> Энэ бугуйн wrist койлыг: **“Wrist 12 ch – аас багагүй”** гэж өөрчлүүлж өгнө үү. Учир нь энэ тендерт байгаа бусад койлны үзүүлэлтүүд маш доогуур байгаа боловч зөвхөн бугуйн койлны үзүүлэлтийг өндөр сувгийн тоотой шаардаж байгаа нь Siemens компанийн MRI аппарат санал болгох компанид л давуу байдал олгож байгаа ба Захиалагч эмнэлэгт ач холбогдол багатай. Бид тус захиалагч байгууллагын хийгддэг MRI шинжилгээ долоо хоногт нэг л тохиолдол орохтой үгүйтэй байхад нурууны MRI өдөрт 5-10 хүн, толгойны MRI өдөрт 8-12 хүн шинжилгээнд ордог ба эдгээр болон бусад олон тохиолдол ордог шинжилгээний койлнуудын сувгийн тоог Siemens – ээс бусад үйлдвэрлэгчдэд байдаг тооноос илүү бага 10 – 18 ch гэж тавьсан байна. Гэтэл толгой, нуруу, хэвлий болон бусад үенүүдийн койлны сувгийн тоо бусад үйлдвэрлэгчдийнх 15 – 44 ch байхад, эдгээр койлны сувгийн тоог зориуд Siemens компанийн MRI онцлогт тохируулж, бууруулж, харин ганц бусад үйлдвэрлэгчээс Siemens-ийн сувгийн тоо нь илүү бугуйн койлыг л зориуд онцолж, хэлбэр төдий өөрчлөлт оруулж, “16 ch” гэж бичсэн мэт сэтгэгдэл төрж байна.<br>Жишээ нь тус тендерийн материалын Соронзон резонанст томографийн аппаратын техникийн үзүүлэлтийн 10. Software хэсэгт: “Биеийн нуруу, нугас, аарцаг, хэвлийн шинжилгээг хамгийн ихдээ 10 – 15 минутад хийх боломжтой технологийг нэвтрүүлсэн байх эсхүл түүнтэй дүйцэх (Энэ нь дийлэнх өвчтөн дээр голчлон хийгддэг шинжилгээ учраас цаг бага зарцуулах нь эдийн засаг болоод эмчийн цагийг хэмнэх ач холбогдолтой)” гэж | Гэмтэл согог судлалын үндэсний төвд өнөөдрийг хүртэл ашиглагдаж буй Соронзон резонанст томографийн аппарат нь суурилагдсан үеэсээ бугуйн шинжилгээг хийх боломжгүй, техникийн хувьд coil болон программууд хэт энгийн (basic) эмчилгээ, оношилгоог сайжруулж, дээшлүүлэх хэмжээнд ашиглахад эмч нарын шаардлагад нийцдэггүй байсан бөгөөд дээр шалтгааны улмаас тухайн шинжилгээ хийгддэггүй байсан. Гэтэл эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, иргэдэд үзүүлж байгаа оношилгоо, эмчилгээний нэр төрөл, технологийг цаг тутамд сайжруулах боломж бололцоо байгааг судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр эрмэлзэж ажиллах нь эмч, мэргэжилтнүүдийн хувьд нэн тэргүүний зорилт бөгөөд эрүүл мэндийн салбарын онцлог юм.<br><br>Иймд тус төв нь гар сарвуу, үений мэс ажилбарыг олон жилийн туршлага, судалгааны дүнд эмчилгээнд нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор оношилгоо, шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийн сайжруулалтыг зайлшгүй хийх шаардлага тулгарсаар байна.<br><br>Тус тендерийн техникийн үзүүлэлтээр шаардлагад бүхий л шаардлагууд нь тендерийн үнэлгээний хорооноос төвийнхөө эмчилгээ, оношилгооны онцлог байдал, ач холбогдлыг бүхэлд нь хамаатуулан авч үзсэний үндсэн гаргасан үзүүлэлт болно.<br><br>Тус үзүүлэлттэй холбоотой та бүхнээс ирүүлсэн өмнөх тодруулгын дагуу өөрчлөлтийг дараах байдлаар оруулсан ба энэхүү ***“Wrist 16*** |

ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ ТЕНДЕРИЙН ХОРОО ТТМ0439 ☏ 90771219 УЛААНБААТАР ХОТ

| | | | |
|---|---|---|---|
| | | Тус эмнэлэг дээр дурдсан 2024 оны 06-р сарын 25-ний өдөр tender.gov.mn сайтад тодруулгын хариундаа ***“тендерийн техникийн шаардлагад аливаа нэг үйлдвэрлэгчийн бусад үйлдвэрлэгчээс ялгарах онцлогийг тусгаж, давуу эрх олгох нь хуулиараа хориотой”*** гэж тунхаглаж бичиж байгаа мөртлөө хэрэг дээрээ энэ бугуйн койлны **“wrist 16 ch багагүй”** гэсэн техник шаардлагаар Siemens компаниас бусад MRI үйлдвэрлэгч нарт өрсөлдөөний хязгаарлалт үүсгэж байна (дээрээс нь ач холбогдол маш бага техник үзүүлэлтийг дөвийлгөж чухал мэт ашиглаж). Бид өмнө нь энэ асуудлаар Танай эмнэлэгт 2024.06.14-ний өдөр Тодруулгын хүсэлт илгээсэн ба танайх үүнд наалтай хариу өгөөгүй тул бид арга буюу Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 2024.06.24-ний болон 2024.06.26-ний өдрүүдэд хандаж энэ асуудлаар гомдол гаргасан ба тус байгууллагаас 2024.07.08-ний өдөр 01/1289 тоот Тодруулгын хариу өгсөн ба үүнд “Захиалагч тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний онцог, үзүүлэлтэд нийцүүлэн боловсруулж, бусад аж ахуй эрхлэгчдийн өрсөлдөх боломжий хязгаарласан шинжтэй байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5-д заасныг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.” гэж дүгнэлт гаргаж ”техникийн тодорхойлолтод холбогдох өөрчлөлт оруулан, ......... захиалагчид даалгасан болно” гэж даалгасан байхад Танай байгууллага өмнө нь тус койлны шаардлагыг Соронзон резонанст томографийн аппаратын техникийн үзүүлэлтийн 10-р бүлэгт байсныг 9-р бүлэг болгож хууран мэхлэх төдий арга хэмжээ авч, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын шаардлагыг биелүүлээгүй байна. | сайжруулахаар ажиллаж байгаагийн хувьд бууруулан өөрчлөх боломжгүй буюу хэвээр үлдээж байна.<br><br>Мөн доорх үндэслэл бүхий тайлбартай танилцана уу.<br><br>**<u>ҮНДЭСЛЭЛ БҮХИЙ ТАЙЛБАР 1:</u>**<br><br>Тендерийн техникийн шаардлагыг боловсруулахад мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн баг дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрлэгч нарын MRI аппаратуудыг интернэтэд суурилсан мэдээлэл дээр тулгуурлан харьцуулсан байдлаар судалгаа хийж, түүнийгээ үндэслэл болгодог болно. **“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн** 12.4. **“Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно.”** гэж заасны дагуу захиалагчийн зүгээс хуульд нийцүүлэн техникийн тодорхойлолтод шаардсан үзүүлэлтийг давуулж эсвэл дүйцүүлэн санал болгох нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд дэлхийн MRI аппарат үйлдвэрлэгч бүх брэндүүд ижил тэгш өрсөлдөх боломжоор хангаж, бүгдэд нийцэхээр зарласан.<br><br>Тендерийн үнэлгээний хорооноос судалж, үндэслэл болгосон мэдээллийг доор зургаар оруулав.<br><br>**<u>“WRIST 16 CH – ААС БАГАГҮЙ” ҮЗҮҮЛЭЛТИЙН ХУВЬД:</u>**<br><br>1. **Саммит медикал сервис ХХК – ийн дистрибьютерийн эрхтэй ажилладаг Philips үйлдвэрлэгч**<br><br><u>dStream HandWrist 16ch coil MR coil \| Philips Healthcare</u> |




2. **Интерсайнс ХХК – ийн дистрибьютерийн эрхтэй ажилладаг GE үйлдвэрлэгч**

<u>1.5T QED 16ch Hand Wrist Coil with the Cable 5768098-2, Magnetic Resonance Imaging | GE HealthCare Service Shop USA</u>



3. **Сетунари ХХК – ийн дистрибьютерийн эрхтэй ажилладаг Siemens үйлдвэрлэгч**

Hand/Wrist 16 - Siemens Healthineers (siemens-healthineers.com)

**Hand/Wrist 16**

< 1 / 5 >



Hand/Wrist 16

4. **Си Ай Ти ХХК – ийн дистрибьютерийн эрхтэй ажилладаг Canon/Toshiba үйлдвэрлэгч**

Integrated Coils | Technology | Magnetic Resonance Imaging | MRI Machine | Canon Medical Systems USA

| | | |
|---|---|---|
| | |  |
| Б) | Соронзон резонанст томографийн аппаратын техникийн үзүүлэлтийн *“9. Coil (Стандарт): - Shoulder small 6 ch – аас ихгүй байх”* гэж шаардсан байна: | |
| | - <u>Өөрчлүүлэх хүсэлт 2:</u> Энэ мөрний жижиг койлыг: ***“Shoulder small 6 ch – аас багагүй байх”*** гэж өөрчилж өгнө үү. Учир нь энэ мөрний жижиг койлны сувгийн тоог 6 сувгаас ихгүй гэсэн шаардлага оруулж байгаа нь Siemens компаний тухайн мөрний койлны бага хүчин чадалтай байгаа сул талыг давуу байдал болгож тендерийн үзэл баримтлалыг алдагдуулж, ямар ч хамаагүй аргаар зөвхөн Сетунари ХХК-д л давуу байдал олгох үйлдэл гэж бид хардаж байна. | Дээр дурдсантай адилаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, иргэдэд үзүүлж байгаа оношилгоо, эмчилгээний нэр төрөл, технологийг цаг тутамд сайжруулахаар ажиллаж байгаагийн хувьд тус төв нь гар сарвуу, үений мэс ажилбарыг олон жилийн туршлага, судалгааны дүнд эмчилгээнд нэвтрүүлээд байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор оношилгоо, шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийн сайжруулалтыг зайлшгүй хийх шаардлага тулгарсаар байгаа болно.<br><br>Иймд тус тендерт техникийн үзүүлэлтийг шаардахдаа нэг бүрчлэн ач холбогдолтой үгүйг судалж, төвийнхөө эмчилгээ, оношилгооны онцлог байдлыг бүхэлд нь хамаатуулан авч үзсэний үндсэн гаргасан бөгөөд тус үзүүлэлттэй холбоотой доорх үндэслэл бүхий тайлбартай танилцана уу.<br><br>**<u>ҮНДЭСЛЭЛ БҮХИЙ ТАЙЛБАР 2:</u>**<br><br>**“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн** 12.4. **“Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно.”** гэж заасны дагуу |

<table>
<tr><td></td><td></td><td>захиалагчийн зүгээс хуульд нийцүүлэн техникийн тодорхойлолтод шаардсан үзүүлэлтийг давуулж эсвэл дүйцүүлэн санал болгох нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд дэлхийн MRI аппарат үйлдвэрлэгч бүх брэндүүд ижил тэгш өрсөлдөх боломжоор хангаж, бүгдэд нийцэхээр зарласан.<br><br><u>“SHOULDER SMALL 6 CH – ААС ИХГҮЙ БАЙХ” ҮЗҮҮЛЭЛТИЙН ХУВЬД</u> тус үзүүлэлтээс ихгүй гэж зааснаас биш <u>6 CH БАЙХ</u> гэж заагаагүй тул тухайн техникийн шаардлагын хамгийн дээд утгаас доошлуулан санал болгох боломжтой юм. Иймд тус үзүүлэлтийг өөрчлөхгүй хэвээр үлдээв.</td></tr>
<tr><td>В)</td><td colspan="2">Соронзон резонанст томографийн аппаратын техникийн үзүүлэлтийн “9. Coil (Стандарт): - Flex coil, Small 4 ch – аас ихгүй байх” гэж шаардсан байна:</td></tr>
<tr><td></td><td>- <u>Өөрчлүүлэх хүсэлт 3:</u> Энэ мөрний жижиг койлыг: “Flex coil, Small 4 ch – аас багагүй байх” гэж өөрчилж өгнө үү. Учир нь энэ жижиг уян койлны сувгийн тоог 6 сувгаас ихгүй гэсэн шаардлага оруулж байгаа нь Siemens компаний тухай мөрний койлны бага хүчин чадалтай байгаа сул талыг давуу байдал болгож тендерийн үзэл баримтлалыг алдагдуулж, ямар ч хамаагүй аргаа зөвхөн Сетунари ХХК-д л давуу байдал олгох үйлдэл гэж бид хардаж байна.</td><td>Тус тодруулгын асуултыг “Flex coil, Small 4 ch – аас багагүй байх” гэж өөрчилж өгнө үү гэж тавьсан хэдий ч доор нь дурдсан тайлбар дээрээ үндсэн тендерийн шаардлагыг “Flex coil, Small 6 ch – аас багагүй байх” гэж ойлгосон мэтээр оруулсан байна. Гэсэн хэдий ч асуултыг доорх байдлаар тавих гэсэн санаа гэж ойлгон хариултыг өгч байна. Үүнд:<br><br>Тендерийн үндсэн техникийн шаардлага “9. Coil (Стандарт): - Flex coil, Small 4 ch – аас ихгүй байх” гэж заасан байх бөгөөд тодруулгаар “Flex coil, Small 4 ch – аас багагүй байх” болгон өөрчлүүлэхийг хүссэн байна. Тус төвийн зүгээс эмчилгээ, оношилгоонд шинэ техник, технологийг нэвтрүүлж байгаагийн хувьд тухайн техникийн шаардлага нь дэлхийн 4 үйлдвэрлэгчид байх боломжтой байгаа тул өөрчлөлт оруулахгүй, хэвээр үлдээж байна.<br><br><u>ҮНДЭСЛЭЛ БҮХИЙ ТАЙЛБАР 3:</u></td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | **"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн** 12.4. **"Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно."** гэж заасны дагуу захиалагчийн зүгээс хуульд нийцүүлэн техникийн тодорхойлолтод шаардсан үзүүлэлтийг давуулж эсвэл дүйцүүлэн санал болгох нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд дэлхийн MRI аппарат үйлдвэрлэгч бүх брэндүүд ижил тэгш өрсөлдөх боломжоор хангаж, бүгдэд нийцэхээр зарласан.<br><br>Тендерийн үнэлгээний хорооноос судалж, үндэслэл болгосон мэдээллийг доор зургаар оруулав.<br><br>**"FLEX COIL, SMALL 4 CH – ААС ИХГҮЙ БАЙХ" ҮЗҮҮЛЭЛТИЙН ХУВЬД:**<br><br>1. **Саммит медикал сервис ХХК – ийн дистрибьютерийн эрхтэй ажилладаг Philips үйлдвэрлэгч**<br><br>dStream Flex S coil MR coil \| Philips Healthcare |




Flexibility for
**multiple applications**

**Key benefits**

- Allows positioning close to anatomy to increase SNR
- Open, non-rigid design offers imaging solutions for challenging cases
- Delivers high resolution and extended coverage in combination with dStream Posterior coil

An integrated coil solution for general-purpose imaging. It includes two small flexible general-purpose coils. Combined with the dStream Posterior coil, you can obtain 10 cm coverage with up to 4 channels.
The shape and size of the flexible coil elements support a wide variety of applications, including imaging of small anatomies. The coil can be used to locally enhance resolution of images acquired over a larger field of view (FOV), for example in pediatric applications.

**2. Интерсайнс ХХК – ийн дистрибьютерийн эрхтэй ажилладаг GE үйлдвэрлэгч**

1.5T 4Ch Small Flex coil collector kit 5430694, Magnetic Resonance Imaging | GE HealthCare Service Shop USA




3. **Сетунари ХХК – ийн дистрибьютерийн эрхтэй ажилладаг Siemens үйлдвэрлэгч**

[4-Channel Flex Coils - Siemens Healthineers USA (siemens-healthineers.com)]




4. **Си Ай Ти ХХК – ийн дистрибьютерийн эрхтэй ажилладаг Canon/Toshiba үйлдвэрлэгч**

[Integrated Coils | Technology | Magnetic Resonance Imaging | MRI Machine | Canon Medical Systems USA]

Magnetic Resonance    Integrated Coils    Contact Us



**4ch Flex SPEEDER Coil**

**Multi-Use**

Galan 3T, Fortian 1.5T, Orian 1.5T and Elan 1.5T

- Lightweight, flexible coil design ensures comfortable scanning in wide variety of anatomies
- SPEEDER Compatible
- Can be combined with spine, body and head coils